

14 хоногийн шуурхай мэдээ

2021.07.23

Сумын Онцгой комиссын 2021 оны 07 сарын 10-ны А/74 тоот захирамжийн хуралдааны шийдвэрээр хяналтын постын үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажиллуулж 24 цагийн хугацаанд 2 хяналтын цэг дээр иргэдийн орох, гарах, зорчих хөдөлгөөнийг хянан бүртгэж нийт баярын өдрүүдэд 8 машин 16 төрийн албан хаагч 24 цагаар ажиллаа.

Сумын шуурхай штаб дээр ЗДТГ-ын дарга Н.Өлзийтогтох 24 цагаар жижүүр хийж постонд гарч буй иргэдийг удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. 2021 оны 07 дугаар сарын 10-ны орой 19 цагийн үед Сумаас зүүн ургаш 6 км Энгэр шанд гэдэг газраас 3 дугаар багийн малчин Д.Мандалгарав гал гарлаа гэсэн дуудлага өгч ИТХ-ын дарга С.Дугарбаатар, Засаг даргын Орлогч Д.Сарангэрэл, ЗДТГ-ын дарга Н.Өлзийтогтох, Сумын хэсгийн төлөөлөгч Э.Ванчиндорж нар газар дээр нь очиж үзэхэд бүрэн шатаж дууссан байсан гэрийн эзэн Д.Мандалгарав малаа услаж байхад утаа гараад байхаар нь ирсэн гэр маань шатаад дуусаж байсан гэсэн мэдүүлэг өгсөн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭМЯ болон УОК, АОК бусад мэргэжлийн байгууллагуудаас өгсөн зөвлөмж, Суманд ажиллаж байгаа үйлчилгээний байгууллагуудын цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэлтэнд хяналт тавьж зөвлөгөө өгч шаардлага тавьж ажиллаж байна.

Мал амьтны гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор отор нүүдэлээр явж байгаа гадны аймгийн 5 өрхийн 4000 гаруй мал, өөрийн аймгийн Сайнцагаан, Луус сумын 5 өрхийн 5000-аад мал, өөрийн сумын 30 гаран өрхийн 20 гаран мянган малд үзлэг хийж ажилласан байна.

Эрүүл мэндийн төв

Голомтонд 716.3 м2, урьдчилан сэргийлж 236 м2 нийт 952.3 м2 газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийгдлээ.

Улаанбаатар хотоос ирсэн болон ойрын хавьтлын 76 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийхэд эерэг тохиолдол 1, PCR оношлуураар 4 хүн нийт 9 иргэнээс коронавирус илэрлээ.

Гэрийн тусгаарлалтанд байсан иргэдээс 22 иргэн, хэвтэн эмчлүүлэх тасгаас 2 иргэн эмчлэгдэн гарлаа.

12оос-17 насны хүүхэд, жирэмсэн, архаг хууч өвчтэй иргэнд Файзер вакциний 1 ба 2 дугаар тунг 98 хүнд хийлээ.

Лабораторит Цусны ерөнхий шинжилгээ 7, Шээсний ерөнхий шинжилгээ 6, цусны бүлэг 4, биохими 2, Дох тэмбүү 2, хеликобактер 1, мазок 2 нийт 26 иргэнд шинжилгээ хийж ажиллаа.

Байгууллагын хагас жилийн санхүүгийн тайлан гарган ажиллаа.

Хүүхдийн цэцэрлэг

Амралтын өдрөөр тогооч М.Амарзаяа, Т.Намрсай, нярав Э.Болормаа нар 24 цагийн хяналтын постонд гарлаа .

Нярав Э.Болормаа тусгаарлах байрны 3 хүнд хоол хийж өглөө.

Тогооч М.Амарзаяа, Т.Намрсай , нярав Э.Болормаа нар 7 хоногт 2 удаа мод услаж байна.

4 туслах багш, жижүүр Р.Мөнгөн-өлзий нар ээлжийн амралт дуусгавар болж ажилдаа орон гадаа талбайн зэрлэг ногоо зулгаалаа.

Ерөнхий боловсролын сургууль

8 түмэн мод аяны хүрээнд тарьж ургуулж буй Монос модны орчмын зэрлэгийг зулгааж, хогыг арилган усалгаа хийв.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ